

## СУМДАД НИЙТЛЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

1. МУЗГ-ын 2020 оны 217, 206 дугаар тогтоолуудаар батлагдсан журмуудыг судалж, шаардлага хангасан төлөвлөлтийг хийж, ЗГХЭГ-ын 2020 оны 100-р тушаалаар батлагдсан загвар аргачлалыг мөрдөж ажиллах
2. Байгууллага бүр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон ажиллах. /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4 дүгээр хавсралтын шалгуур үзүүлэлтийг хангасан төлөвлөлтийг хийх/
3. Төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгай удирдамжийн дагуу хяналт шинжилгээ хийж, байгууллагуудын үйл ажиллагааг жигд сайжруулах.
4. Аймгийн Засаг даргатай сумын Засаг даргын байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтэд улирал бүр хяналт шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч болзошгүй заалтуудыг эрчимжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч гэрээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналтыг тогтмол тавьж байх.
5. Хууль тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, шинээр гарч байгаа хууль дүрэм, журмыг судлах асуудлыг төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөө болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилт үр дүнг тооцох.
6. Бүх байгууллага хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 5 дугаар тогтоолын дагуу бүрэн бүрдүүлэх
7. Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах, төлөвлөгөө гаргаж тайлагнаж ажиллах, ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах
8. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээг Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан 14 шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайт, болон мэдээллийн самбарт байршуулах, мэдээллээ шинэчилж ажиллах
9. Төрийн албан хаагчдын баримт бичиг боловсруулах, төлөвлөх, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх
10. Захиргааны хэм хэмжээ тогтоосон аймгийн Засаг даргын 2019 оны А/394 тоот захирамжийн хавсралтаар батлагдсан "Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон ажиллах.
11. Монгол бичгийн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулж, сургалтын үр дүнийг шалгалтыг өгч батламж авахуулсан байх.
12. Ургийн бичиг хөтөлж байгаа айл өрхийн нарийвчилсан судалгааг гаргаж, үр дүнг тооцох.

13. Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх буюу Захирамжлалын баримт бичгийн төсөлд хяналтын дагалдах хуудас хэрэглэх.

14. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажилд "Эрх зүйн хөтөч" нарыг багаар ажиллуулан тэдэнд дэмжлэг үзүүлж, эрх зүйн сургалт сурталчилгааг 16-гаас дээш насны иргэдийн 15 хүртэлх хувьд хүргэх.